

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

2023 оны 9-р сар

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хариуцах хэлтэс, нэгж	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
26	38	Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай 2023-05-24 Дугаар 2023_201	1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах, зорчигч тээврийн урсгалыг нэмэгдүүлэх, зорчигчийн тийсийн үнийг хямдруулах зайлшгүй шаардлагыг харгалзан 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улаанбаатараас орон нутгийн зарим чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "МИАТ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир нарт даалгасугай.	МИАТ	Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК "Монголд зочлох жил"-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 8 аймгийн чиглэлд долоо хоногийн 1-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхлэсэн. Эхний нислэгийг УБ-Ховд-УБ чиглэлд гүйцэтгэсэн. 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар орон нутгийн хуваарьт 8 чиглэлд, 165 удаа нислэг үйлдэж, 1332 зорчигч тээвэрлэсэн байна. МИАТ ТӨХК ийнхүү орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэж эхэлснээр дотоодын зорчигчиддоо хүртээмжтэй, хямд, тав тухтай, шуурхай зорчих боломжийг олгохоос гадна гадаадын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм. МИАТ ТӨХК үндэсний агаарын тээвэрлэгчийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд харьцангуй хямд үнийг санал болгож байна. Тухайлбал: өмнө нь Өлгий, Ховд чиглэлд нислэгийн тийз хоёр талдаа 1,5-1,7 сая байсан бол 810,000-902,000, Улаангом, Улиастай руу 1,3-1,4 сая байсан бол 633,000-852,000 болж 2-2,5 дахин хямдруулсан. Мөн Даланзадгад руу хоёр талдаа 500,000-617,000, Мөрөн рүү 500,000-680,000, Алтай руу 733,000-852,000, Чойбалсан руу 537,000-617,000 төгрөгийн тарифаар нислэг үйлдэж байна. Түүнчлэн орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх болсонтой холбоотойгоор ӨАБНУ-ын "CEM AIR" компаниас CRJ-200 маягийн агаарын хөлгийг 2023.06.22-ны өдрөөс эхлэн нойтон түрээсийн гэрээгээр түрээслэн авсан.	100%
	39		2. Орон нутгийн нислэгийн үйл ажиллагааг эхлүүлж, нислэгт дунд оврын агаарын хөлөг шинээр ашиглахад "МИАТ" ТӨХК-д шаардагдах 8.6 тэрбум (найман тэрбум зургаан зуун сая) төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Иргэний нисэхийн ерөнхий газар ("Ч.Мөнхтуяа")-т тус тус даалгасугай.	МИАТ	Орон нутгийн нислэгийн үйл ажиллагааг эхлүүлж, нислэгт дунд оврын агаарын хөлөг шинээр ашиглахад шаардагдах 8.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх Засгийн газрын тогтоолын дагуу 2023.06.30-ны өдрийн байдлаар МИАТ ТӨХК болон ИНЕГ-тай хоорондын тооцоо нийлж, санхүүжилтийг авахаар болсон.	100%
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ						
51	77	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIV.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	МИАТ	Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийгдсэн судалгааны ажил 2023 онд байхгүй болно.	

54	82	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	ХҮ.6. 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай уялдуулан Монголын иргэний агаарын тээврийн "МИАТ" ТӨХК-ийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "МИАТ" ТӨХК (Б.Мөнхтамир)-д даалгав.	МИАТ	МИАТ ТӨХК нь 2023 оны хагас жилийн байдлаарх хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 338 тэрбум төгрөгийн орлого олж, 293 тэрбум төгрөгийн зардал гарган, 45 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаж байна. 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар олон улсын хуваарьт 11 чиглэлд, орон нутгийн 9 чиглэлд, захиалгат 6 чиглэлд, 1939 удаагийн аялал үйлдэж, 561,904 зорчигч тээвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 120 хувь өссөн байна. Б767, Б737, Б787 агаарын хөлгөөр хуваарьт 765 удаагийн нислэгээр Карго ачаа 2336 тонн, Шуудан 122 тонн, Б757 агаарын хөлгөөр захиалгат 87 удаагийн нислэгээр 2270 тонн ачаа, Транзит ачаа 987 тонн тус тус тээвэрлэсэн. МИАТ ТӨХК болон AerCar компаниуд 2023 оны 5 дугаар сард хоёр ширхэг 787-9/Dreamliner/ төрлийн агаарын хөлгийг үйл ажиллагааны урт хугацааны түрээсээр авах гэрээг байгуулж, эхний 787-9 агаарын хөлгөө 2023.08.11-ний өдөр хүлээн авсан Хоёр дахь 787-9 агаарын хөлгийг 2024 оны эхний улиралд хүлээн авна. Аялал жуулчлалын оргил үе, зуны нислэгийн хугацаанд ХБНГУ-ын Франкфурт, БНТУ-ын Истанбул хот руу аялж буй зорчигчдоод ая тухтай, шуурхай үйлчлэх зорилгоор өргөн биет Б767-300 ER агаарын хөлгийг АНУ-ын "Omni Air International" компаниас нойтон түрээсийн зарчмаар 2023.06.20-2023.08.14-ний өдрийн хооронд 2 сарын хугацаатай түрээслэн авч нислэг үйлдвэрлэлдээ ашигласан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 264 дүгээр тогтоолоор 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Аялал жуулчлалыг дэмжих тусгай тарифийг Өвлийн улиралд (2023.01-04 сар, 2023.10-2024.04 сар) 4 болон түүнээс дээш хүнд 19-44 хувь хямд тариф, Зуны улиралд (2023.05-2023.09 сар) 10 ба түүнээс дээш хүнд 12-30 хувь хүртэл хямд тусгай тариф тус тус гарган зах зээлд нэвтрүүлсэн. 2023 оны зуны нислэг болох аялал жуулчлалын оргил үед Европын чиглэлд Франкфурт хот руу долоо хоногт 6, Истанбул хот руу долоо хоногт 3, Азийн чиглэлд Сөүл хот руу өдөрт 2-3, Бээжин, Хонконг, Токио руу өдөр бүр, Гуанжоу руу долоо хоногт 2, Пусан руу долоо хоногт 4 удаа, Осака руу долоо хоногт 2 удаа болгон нислэгийн давтамжийг нэмэгдүүлсэн. Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК "Монголд зочлох жил"-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 9 аймгийн чиглэлд долоо хоногийн 1-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхлэсэн. Эхний нислэгийг УБ-Ховд-УБ чиглэлд гүйцэтгэсэн. Түүнчлэн орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх болсонтой холбоотойгоор ӨАБНУ-ын "CEM AIR" компаниас CRJ-200 маягийн агаарын хөлгийг 2023.06.22-ны өдрөөс эхлэн нойтон түрээсийн гэрээгээр түрээслэн авсан. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан ЗТХСайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын дагуу МИАТ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/188 дугаар тушаалаар 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний нэгж тус бүрийн үйлчилгээний чанар, гадаад үзэмж, харилцаа хандлагыг сайжруулах, нислэгийн үеийн зорчигч үйлчилгээний бүтээгдэхүүний загвар дизайныг шинэчлэх, олон улсын Скайтракс-4 одны зэрэглэл авах аудит шалгалтад бэлтгэх зэрэг 18 бүлгээс бүрдсэн 234 төлөвлөгөөт ажлын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
----	----	--	---	------	--	------